



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 10 сарын 18 өдөр

Дугаар А/91

Мөрөн сум

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг
хойшлуулж, хурлын тов тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.11, 48 дугаар зүйлийн 48.3, 52 дугаар зүйлийн 52.1.10, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, Компанийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.2, 61.2, 61.7 дахь хэсэг 69 дүгээр зүйлийн 69.3, 69.6, 69.7 дахь хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 377 дугаар тогтоол, “Могойн гол” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.2, 7.6, “Могойн гол” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулах журмын 3 дугаар зүйлийн 3.1, 4 дүгээр зүйлийн 4.1 дэх заалт, тооллогын комиссын тэмдэглэл, тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Могойн гол” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус, хойшлогдсон хурлыг 2023 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 11 цагт, Хөвсгөл аймаг, Мөрөн сум, Удирдлагын ордон “А” байр, 3-р давхар “Иргэний танхим”-д хийхээр товлосугай.

2. Энэхүү захирамж батлагдсантай холбогдуулан хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөө болон бүртгэх өдөрт өөрчлөлт орохгүй бөгөөд энэ тухай хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд хүргэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.

3. Хойшлогдсон хурлыг дахин мэдээлэх өдрийг 2023 оны 10 дугаар сарын 19-ний өдрөөр, хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлийг 01 дүгээр хавсралтаар, хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлийн хяналтын хуудсыг 02 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

ДАРГА



Г.МӨНГӨНХУЯГ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын даргын 2023 оны 10 дугаар
сарын 18 өдрийн 19 дугаар
захирамжийн 01 дүгээр хавсралт

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ


Компанийн нэр	"Могойн гол" ХК
Хаяг, утас	Хөвсгөл аймаг, Цэцэрлэг сум, 7-р баг, утас:99898922, 99058438
Хурал хуралдах өдөр, цаг	2023 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 11.00 цагт
Хурал хуралдах газар /хаяг, байршил/	Хөвсгөл аймаг, Мөрөн сум, аймгийн ЗДТГ-ын "А" байр, III давхар, "Иргэний танхим"-д
Хурлын төрөл:	Ээлжит бус
Хурал зарлагч	Орон нутгийн өмчийн 51 хувийг эзэмшигч- Хөвсгөл аймгийн ИТХ
Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо	2023.10.18
Олон нийтэд зарлах огноо	2023.10.19
Бүртгэх өдөр	2023.09.25
Гэрээний дагуу хурлын баримт, бичгийг брокер, дилерийн компанид хүргүүлэх огноо	2023.09.11
Хүргүүлсэн огноо	2023.09.11
Хурлын даргын нэр	Н.Төмөрхуяг
Тооллогын комиссын дарга, гишүүдийн нэр	Комиссын дарга: Б.Одончимэг Гишүүд: Б.Угтах-Эрдэнэ
Баримт, бичгийн жагсаалт /хавсралтаар/	<ul style="list-style-type: none">- Хурал хуралдуулах тухай шийдвэр, хурлын тэмдэглэл- Хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээллэх зарын загвар- Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээллийн жагсаалт, бэлэн болгох эцсийн хугацаа
Баримт, бичгийн хуудасны тоо хуудас

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН
ДАРГА Н.ТӨМӨРХУЯГ

2023 оны 10 дугаар сарын 18



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын даргын 2023 оны 10 дугаар
сарын 18-ны өдрийн 19 дугаар
захирамжийн 02 дугаар хавсралт



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЛИЙН ХЯНАЛТЫН ХУУДАС

№	ЗҮЙЛ	ТАЙЛБАР
1	Компанийн нэр	"Могойн гол" ХК
2	Хаяг, байршил	Хөвсгөл аймаг, Цэцэрлэг сум, 7-р баг
3	Хурал зарласан огноо	2023.10.18
4	Хурал зарлагчийн мэдээлэл	Аймгийн ИТХ
5	Хороонд ирүүлсэн огноо	2023.10.19
6	Олон нийтэд зарлах огноо	2023.10.19
7	Хурал хуралдахаас ажлын 7 хоногийн өмнө олон нийтэд зарласан эсэх	Тийм
8	Бүртгэлийн өдөр	2023.09.25 /тийм/
9	Хэлэлцэх асуудал	1. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай
10	Саналын хуудасны загвар	Аймгийн ИТХ-ын даргын 2023 оны 10 дүгээр сарын 18-ны өдрийндугаар захирамжийн 03 дугаар хавсралтаар
11	Саналын хуудас хүлээн авах өдөр	2023.10.06
12	Хурлын даргын нэр	Н.Төмөрхуяг
	Хурлын тооллогын комиссын гишүүдийн нэр	Комиссын дарга: Б.Одончимэг Гишүүд: Б.Угтах-Эрдэнэ
13	Хурал хуралдах огноо	2023.10.30
14	Хурал хуралдуулах газар, байршил	Хөвсгөл аймаг, Мөрөн сум, АЗДТГ-ын "А" байр III давхар, "Иргэний танхим"-д
	Хурал хуралдуулах огноо, цаг	2023.10.30, 11:00
15	Хурлын мэдэгдэл хянасан хянан шалгагчийн нэр	
	Хурлын мэдэгдэл хянасан хянан шалгагчийн гарын үсэг	
	Хурлын мэдэгдэл хянасан огноо	